

ХҮҮХДИЙН СПОРТЫН VI ИХ НААДМЫН АНХАН ШАТНЫ ТЭМЦЭЭН

“ ЦАНА ”

“Анхдагчдын цом-2019” гүйлтийн цанын Өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнийг Бугат суманд амжилттай зохион байгуулж эмэгтэй 35, эрэгтэй 45 нийт 80 тамирчид оролцлоо. Тэмцээнийг Биеийн тамир, спортын газар, Бугат сумын ЗДТГазар, ЕБСургууль, аймгийн ЗДТГазар хамтран зохион байгууллаа. Өсвөр үеийн тамирчдаас багийн дүнгээр I байранд Ю.Соёлмаа ахлагчтай Булганы 2-р баг, II байранд П.Баярсайхан ахлагчтай Булганы 1-р баг шалгарсан байна.



“ ЖУДО БӨХ ”

Жүдо бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах нөхөрсөг тэмцээн 2019 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр МСҮТөвийн спортын зааланд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд БТСГазар, МСҮТөв, Сонгино хайрхан, Ханхүс, Могод сумын нийт 7 байгууллагын 115 тамирчин оролцлоо. Багийн дүнгээр: I байранд МСҮТөвийн Х.Батхишиг дасгалжуулагчтай баг, II байранд Сонгино хайрхан, III байранд БТСГазрын С.Лхагвасүрэн дасгалжуулагчтай баг тамирчид шалгарсан байна.



“ ТЭШҮҮР ”

Булган сумын Засаг даргын нэрэмжит Хүүхдийн спортын VI их наадмын хүрээнд өсвөрийн тэшүүрчдийн тэмцээнийг 2019 оны 02 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд Булган сумын Төв цэнгэлдэх хүрээлэнгийн “Мөсөн гулгуур”-ын талбайд амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд нийт 9 байгууллагын 82 өсвөрийн тэшүүрчид оролцсоноос багийн дүнгээр I байр Ц.Дэмбэрэлмаа дасгалжуулагчтай Хишиг-Өндөр



сум, II байр Б.Батбямба дасгалжуулагчтай ЭӨЦСургууль, III байр Гантулга дасгалжуулагчтай Хутаг-Өндөр сумын баг тамирчид шалгарлаа. Тэмцээний үеэр Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн Биеийн тамирын багш Ё.Пүрэвдоржийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын шагнал “Спортын алдар” тэмдгээр шагнаж урамшуулав.

“САГСАН БӨМБӨГ”

Булган аймгийн Хүүхдийн спортын VI наадмын Сагсан бөмбөгийн ААШТэмцээн 02 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Булган суманд амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 29 багийн эмэгтэй 63, эрэгтэй 152 нийт 215 тамирчид оролцож багийн дүнгээр I байранд Гончигжанцан дасгалжуулагчтай ЭӨЦСургууль, II байранд Н.Болормаа дасгалжуулагчтай Хутаг-Өндөр сум, III байранд Б.Бат-Эрдэнэ дасгалжуулагчтай I-12 жилийн сургуулийн баг тамирчид шалгарч медалийн эзэд болсон байна.

“ ШАТАР ”

Монголын хүүхдийн спортын VI их наадмын хүрээнд Монгол улсын гавъяат багш, шатрын холбооны дэд мастер Жамъяндоржийн Пүрэвсүрэнгийн нэрэмжит өсвөрийн шатарчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2019 оны 02 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд 7 насны ангилалаар зохион байгууллаа. Тэмцээнд 15 сумын 18 багийн 317 шатарчин оюун ухаанаа сорин өрсөлдсөнөөс багийн дүнгээр Тэргүүн байрыг



Д.Нэргүй, Б.Отгонсүрэн, Д.Энхмөнх дасгалжуулагчтай Эрдмийн өргөө цогцолбор сургууль, дэд байрыг Ж.Амарбаясгалан дасгалжуулагчтай Хутаг-Өндөр сум, гутгаар байрыг С.Наранбаатар дасгалжуулагчтай 1-12 жилийн бүрэн дунд сургуулийн баг тамирчид тус тус эзэллээ. Тэмцээний ивээн тэтгэгчээр "Сөрт" клуб Ж.Пүрэвсүрэн, "Булган Сэлэнгэ" ХХК Д.Нэргүй, ерөнхий зохион байгуулагчаар Биеийн тамир, спортын газар, Булган аймгийн шатрын холбоо хамтран зохион байгууллаа.

“ВОЛЕЙБОЛ”

Хүүхдийн спортын VI наадмын анхан шатны волейболын тэмцээнийг 03 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд Булган суманд зохион байгуулж 13 багийн эмэгтэй 103, эрэгтэй 108 нийт 211 тамирчин оролцлоо.



“ШИРЭЭНИЙ ТЕННИС”

Монголын Хүүхдийн спортын VI наадмын анхан шатны Ширээний теннисний аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 7 багийн эмэгтэй 15, эрэгтэй 32 нийт 47 тамирчид оролцож багийн дүнгээр Баяннуур сумын баг тамирчид эхний байранд шалгарлаа.



“ БУУДЛАГЫН ТЭМЦЭЭН ”

Булган аймгийн буудлагын аварга шалгаруулах тэмцээнд 113 тамирчин цэц мэргэнээ сорьсноос:Эмэгтэй урт бууны төрөлд 1.Б.Отгонсүрэн (98.7), 2.Б.Ариунжаргал (94.5)ОБГ, 3.Б.Мөнхжаргал (88.8), Эрэгтэй урт бууны төрөлд 1.Ш.Баасандорж (103.3)ОБГ, 2. Амгалан (100.3)ЭБЦТС, 3.Н.Бямбабаяр(94.1)Татварын газар, Эмэгтэй гар бууны төрөлд 1.Д.Номинчимэг (75) 3-сургууль, 2.П.Хишигдаваа (70) Шүүх, 3. Хонгорзул (64) ОБГ, Эрэгтэй гар бууны төрөлд1. Ж.Энхболд (76) Цагдаа 2.Ц.Наранбат (73) 3-р сургууль, 3.Г.Намнан (68) АЗДТГ, Багийн дүнгээр I байранд ОБГазар, II байранд III дугаар сургууль, III байранд Аймгийн ЗДТГазар тус тус эхний байруудад шалгарлаа.



“ ЖҮДО БӨХ ”

Жүдо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 03 дугаар сарын 16-18 өдрүүдэд болж 14 байгууллагын 275 тамирчид 40 жингийн ангилалд өрсөлдөж Багийн дүнгээр I байр МСҮТөв, II байр СДСургууль, III-байр Баян-Агт сум, Ахлах нас: 42кг I байр Б.Намжилсүх, 46 кг I байр Б.Отгонбилэг, 50кг I байр А.Ганбүргэд, 55кг I байр Т.Буяннэмэх, 60кг I байр Г.Сумъяабазар, 66кг I байр М.Мөнхсүх, 73кг I байр Д.Бадамдорж, -81 кг I байр С.Саранцогт, +81кг I байр Д.Баасансүрэн нар аваргууд боллоо.



“ САМБО БӨХ ”

Самбо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 03 дугаар сарын 18-20 өдрүүдэд болж 14 байгууллагын 165 тамирчид 17 жингийн ангилалд өрсөлдөж аваргууд тодорлоо. Багийн дүнгээр I байр СДСургууль, II байр МСҮТөв, III байр Бүрэгхангай сум шалгарлаа.



“ ЧӨЛӨӨТ БӨХ ”

Хүүхдийн спортын VI наадмын Чөлөөт бөхийн ААШТэмцээнд 9-н байгууллагын 88 тамирчид оролцож эрэгтэй багийн 1-р байр Цогтбаяр багштай Спортын дунд сургууль 2-р байр Атарсүрэн багштай Хутаг-Өндөр сум "Баатарван клуб", 3-р байр Ганбат дасгалжуулагчтай Сайхан сумын баг тамирчид, Охидын баг 1-р байр Хутаг-Өндөр

"Баатарван клуб", 2-р байр М.Эрдэнэ-Очир дасгалжуулагчтай Баяннуур сум, 3-р байр Золбадрах дасгалжуулагчтай Хишиг-Өндөр сумын баг тамирчид тус тус шалгарлаа.



“ХӨНГӨН АТЛЕТИК”

Хүүхдийн спортын наадмын хөнгөн атлетикийн анхан шатны тэмцээнд 10 сумын 14 багийн эмэгтэй 100, эрэгтэй 140 нийт 240 тамирчид авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдсөнөөс тэргүүн байранд багийн дүнгээр Хутаг-Өндөр сум шалгарсан байна.

“ 3Х3 САГСАН БӨМБӨГ “

3х3 Сагсан бөмбөгийн тэмцээн Булган суманд 2019 оны 04 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 13 багийн 52 тамирчин оролцлоо.



“АХМАД ТАМИРЧДЫН СПОРТЫН НААДАМ “

Ахмадын хөгжлийг дэмжих жилийн ажлын хүрээнд зохион байгуулагдсан "Ахмад тамирчдын спортын наадам" 2019 оны 09 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Булган суманд Хөнгөн атлетик, граунд гольф, софт волейбол, дартс, ширээний теннис, шатар гэсэн спортын 6 төрлөөр зохион байгуулагдлаа. Тус наадамд 15 сумын 263 ахмад тамирчин оролцож багийн нэгдсэн дүнгээр Булган сум, Сэлэнгэ сум, Хишиг-Өндөр сумын баг тамирчид шалгарсан байна.

